



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.03.24 № 3/556
танай _____-ны № _____-т

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА, БРИГАДЫН
ГЕНЕРАЛ Ц.АМГАЛАНБАЯР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.


Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



Нэг. Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8.9.2, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1 дэх заалтыг үндэслэн Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд САГ-2017/11/СТА-ТТЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, шударга бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг 2017 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн 07/792 дугаартай албан бичгийн хамт Үндэсний аудитын газарт хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 3 дугаар сарын 15-наас 3 дугаар сарын 23-ны өдрийн хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын ахлах аудитор Д.Ганбилэг, шинжээч Б.Баярмаа нар гүйцэтгэж, аудитын тайланг хуулийн хугацаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын удирдлагад гардуулна.

Хоёр. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

ШШГЕГ-ын эрхэм зорилго нь шүүхийн шийдвэрийг нэг мөр гүйцэтгэж, цагдан хорих, баривчлах болон хорих ял эдлүүлэх үйл ажиллагааг олон улсын жишгийн түвшин, хуулийн хүрээнд зохион байгуулах, эд хөрөнгийн холбогдолтой шийдвэр

бүрийн биелэлтийг хангах, үйлчлүүлэгч, хэрэглэгчдэд шуурхай үйлчлэхэд оршино гэж зорилтыг тодорхойлсон байна.

Тус газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгаж, баримтжуулсан.

ШШГЕГ-ын төсвийн захирагч нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журам, өөрийн байгууллагын баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн хүрээнд төсөв, санхүү бүртгэлийн үйл ажиллагаагаа эрхлэн гүйцэтгэж байна.

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг гол шалгуураа болголоо.

Аудитаар ШШГЕГ-ын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, гүйлгээ ихтэй 5 дансад түүвэрчилсэн байдлаар аудитын горим, сорил 13-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн материаллаг бус зөрчилтэй зарим асуудлыг хураангуйлан тэмдэглэв.

ШШГЕГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг удирдлага болгон ажиллаж байна.

ШШГЕГ-ын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн

мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

ШШГЕГ-ын бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн "Юникус" програм хангамж ашиглаж боловсруулан, санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргажээ.

ШШГЕГ-ын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн материаллаг байдлын үнэлгээг гүйцэтгэлийн шатанд нийт үйл ажиллагааны зардлын 2 хувь буюу 1,461.5 сая төгрөгөөр тогтоов.

Тав. Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

ШШГЕГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Зургаа. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

ШШГЕГ-ын 2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлэхээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

ШШГЕГ 2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

ШШГЕГ тайлант хугацаанд нийт 57,663.7 сая төгрөгийн зардлын санхүүжилт батлагдаж улсын төсвөөс 52,649.8 сая төгрөгийн санхүүжилт авахаас 52,440.3 сая төгрөг буюу 99.6 хувь, туслах үйл ажиллагааны орлого 4,798.5 сая төгрөгөөр батлагдсанаас 4,677.1 сая төгрөг буюу 97.4 хувь, НДС-аас санхүүжих 215.4 сая төгрөг авахаас 100 хувь санхүүжилт авч зарцуулсан байна. Нийт 56,303.4 сая төгрөгийн зардлын зарим хэсэг зүйл ангиар хэтэрсэн боловч бүлгийн дүнгээр хэтрээгүй байна.

Долоо. Шилэн дансны мэдээлэл

ШШГЕГ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Тухайлбал: Тус газар өөрийн цахим хуудсанд "Шилэн дансны мэдээлэл" нэртэй цэс үүсгэж, төсөв санхүүгийн ил тод байдал, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах ил тод байдал гэсэн багц мэдээллийг нээлттэй ил тодоор тухай бүр мэдээлж байна.

Мөн мэдээллийн ил тод байдал, тайлан зэрэг цэсүүдийг үндсэн үйл ажиллагаа болон төсөв, санхүүгийн шаардлагтай мэдээллийг ил тод мэдээлэх зорилготой ажиллуулж байна.

Найм. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу уламжлалт болон хяналтын 13 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Ес. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар

ШШГЕГ-ын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, өглөг болон бараа үйлчилгээний орлого, зарлага зэрэг дансад ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцоолуудыг түүвэрлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Арав. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар.

ШШГЕГ болон эрхлэх асуудлын хүрээний 58 байгууллагын 67 хувь буюу 34 байгууллага аудитад хамрагдаж, 17 хувь буюу 10 байгууллага түүвэрт, 8.6 хувь буюу 5 байгууллагад итгэл үзүүлсэн байна.

Аудитад хамрагдсан байгууллагууд зөрчилгүй дүгнэлт авсан бөгөөд аудитаар 37.4 сая төгрөгийн 6 төлбөрийн акт, 38.0 сая төгрөгийн 5 албан шаардлага, 495,5 сая төгрөгийн 57 зөвлөмж өгч, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд 413.9 сая төгрөгийн 25 залруулга хийгдэж, 5.6 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцсон зэрэг нийт 990.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна.

1.ШШГЕГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 279.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд менежментийн захидлаар 4 зөвлөмж өгөв. Үүнд:

- ✓ 1.2 Санхүүгийн нэгтгэсэн тайланд туссан нийт авлагаас 18 иргэн, аж ахуйн нэгжтэй холбоотой, эзэн холбогдогч нь тодорхойгүй 78.5 сая төгрөг, тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй 23 аж ахуйн нэгж иргэний 37.2 сая төгрөг, санхүүгийн тайланд тусгасан авлагын дүнтэй тооцоо нийлсэн актын дүн зөрүүтэй, тамга тэмдэг дарж албажуулаагүй 40.5 сая төгрөгийн авлага тус тус байгаа нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах" заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар зөвлөмж өгөх.

1.3 Санхүүгийн нэгтгэсэн тайланд туссан нийт өглөгөөс 13 аж ахуйн нэгж иргэний 39.3 сая төгрөг, ялтанд өгөх цалин болон ялтан сэжигтний нэрийн дансны үлдэгдэл 84.2 сая төгрөгийн өглөгүүдийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах” заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар зөвлөмж өгөх.

2. Аймгийн аудитын газар болон гэрээний үндсэн дээр хувийн аудитын компаниар аудитад хийлгэсэн ШШГЕГ-ын харьяа 27 хорих анги, ШГА, ТӨААТҮГ-т нийт 37.4 сая төгрөгийн 6 төлбөрийн акт, 38.0 сая төгрөгийн 5 албан шаардлага, 215.8 сая төгрөгийн 53 зөвлөмж өгч, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд 413.9 сая төгрөгийн 25 залруулга хийгдэж, 5.6 сая төгрөгийн 97 толгой малыг холбогдох шийдвэргүй акталсанд хариуцлага тооцсон зэрэг нийт 710.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна. Үүнд:

Төлбөрийн акт

2.1 Нийт 37.4 сая төгрөгийн 6 төлбөрийн акт тогтоосноос 32.6 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө дутуу биелүүлсэнтэй холбоотой, 3.6 сая төгрөгийн ажилчдын цалингаас ХХОАТ суутгасан боловч дутуу тайлагнасанатай холбоотой, 1.2 сая төгрөг анхан шатны баримтгүй, хууль эрх зүйн үндэслэлгүй зардал гарсантай холбоотой байна.

Албан шаардлага

2.2 Нийт 38.0 сая төгрөгийн 5 албан шаардлага тогтоосноос 11.8 сая төгрөг хөрөнгө худалдан авах болон хөрөнгийн бүртгэлтэй холбоотой, 11.6 сая төгрөг зориулалт бусаар зарцуулсан, 14.6 сая төгрөг худалдан авах ажиллагаатай холбоотой албан шаардлага байна.

Шийдвэрлэсэн нь: ШШГЕГ-ын нэгтгэсэн байдлаар менежментийн захидлаар зөвлөмж өгөх

Арван нэг. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

ШШГЕГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар залруулагдаагүй алдаа гараагүй байна.

Арван хоёр. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар анхаарал татахуйц чухал асуудал алга байна

Арван гурав. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

1.САГ-ын хүн хүчний болон цаг хугацааны нөөц боломжоос шалтгаалан ШШГЕГ-ын харьяа УБ хотын бүсийн хорих ангиудын санхүүгийн тайланг баталгаажуулж, дүгнэлт гаргах ажил бүрэн хэмжээгээр хийгдэхгүй байгааг анхаарах, эсхүл Нийслэлийн аудитын газраар аудит хийлгэх.

2.ШШГЕГ-ын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгагдсан Шүүхийн шийдвэрээр хохирогчдод олгох мөнгөний эх үүсвэр, бүрдүүлэлт, төлөлтийг шалгаагүй болно.

Арван дөрөв. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

ШШГЕГ болон эрхлэх асуудлын хүрээний 58 байгууллагын 67 хувь буюу 34 байгууллага аудитад хамрагдаж, 17 хувь буюу 10 байгууллага түүвэрт, 8.6 хувь буюу 5 байгууллагад итгэл үзүүлсэн байна. Аудитад хамрагдсан байгууллагууд зөрчилгүй дүгнэлт авсан бөгөөд аудитаар нийт 990.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс санхүүгийн тайлагналтай холбоотой 413.9 сая төгрөгийн 25 залруулга хийгдсэн байна.

Арван тав. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

ШШГЕГ-ын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газар аудит хийж 3 зөвлөмж өгсөний 1 хэрэгжээгүй байна.


Арван зургаа. Зөвлөмж

ШШГЕГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 279.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд менежментийн захидлаар 4 зөвлөмж өгч байна.

Арван долоо. Зөрчилгүй санал дүгнэлт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлангууд болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн, шударга илэрхийлэгдсэн байна.

АУДИТЫН ТАЙЛАНГ

<u>ХЯНАСАН:</u> САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		/Ц.НАРАНЧИМЭГ/
АУДИТЫН МЕНЕЖЕР		/Я.САМБУУНЯМ/
<u>БЭЛТГЭСЭН:</u> АХЛАХ АУДИТОР		/Д.ГАНБИЛЭГ/
ШИНЖЭЭЧ		/Б.БАЯРМАА/

2017.03.20



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Асуудал 1

- Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Асуудал 2

- Авлага

Асуудал 3

- Өглөг

Асуудал 4

- Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар илэрсэн зөрчил дутагдал

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Төсвийн ерөнхийлөн захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгасан болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Төсвийн төвлөрүүлэн захирагчийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АСУУДАЛ 1: Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаар

Ажиглалт

ШШГЕГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн өмнөх аудитаар өгсөн 3 зөвлөмжөөс 1 хэрэгжээгүй байна.

Зөвлөмж

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12, МУ-ын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан журмын 8 дугаар зүйлийн 8.1-д “санхүүгийн тайлангийн аудитаар тавьсан акт, албан шаардлагын биелэлтийг тогтоосон хугацаанд хариуцагчаас албан бичгээр гаргуулан авах ба завсрын аудитаар бид давтан шалгана” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах

Эрсдэл

Зөрчил дутагдал давтагдан гарах, арилахгүй байх, уламжлалт эрсдэл бий болох, тоон мэдээлэл буруу илэрхийлэгдэх

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг танилцуулсан болно

АСУУДАЛ 2: Авлагын талаар

Ажиглалт

Нэгтгэсэн санхүүгийн тайланд туссан нийт авлагаас 18 иргэн, аж ахуйн нэгжтэй холбоотой, эзэн холбогдогч нь тодорхойгүй 78,483.1 мянган төгрөгийн авлага, тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй 23 аж ахуйн нэгж иргэний 37,199.7 мянган төгрөг, санхүүгийн тайланд тусгасан авлагын дүнтэй тооцоо нийлсэн актын дүн зөрүүтэй, тамга тэмдэг дарж албажуулаагүй 40,504.3 мянган төгрөг буюу нийт 156,187.1 мянган төгрөгийн авлага байгаа нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах” заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Эрсдэл

Санхүүгийн тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх, байгууллага хувь хүмүүстэй хийх тооцоо эзэнгүйдэх, найдваргүй авлага үүсэх

Зөвлөмж

НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” заалтыг хэрэгжүүлж ажиллах

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг танилцуулсан болно

АСУУДАЛ 3: Өглөгийн талаар

Ажиглалт

Нэгтгэсэн санхүүгийн тайланд туссан нийт өглөгөөс 13 аж ахуйн нэгж иргэний 39,308.0 мянган төгрөгийн өглөг, ялтанд өгөх цалин болон ялтан сэжигтэний нэрийн дансны үлдэгдэл 84,189.0 мянган төгрөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах” заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Эрсдэл

Санхүүгийн тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх, байгууллага хувь хүмүүстэй хийх тооцоо эзэнгүйдэх, хөрөнгийн ашиглал үүсэх

Зөвлөмж

НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах” заалтыг хэрэгжүүлэх

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг танилцуулсан болно

АСУУДАЛ 4: Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар илэрсэн зөрчил дутагдал

Ажиглалт

Аймгийн аудитын газар болон гэрээний үндсэн дээр хувийн аудитын компаниар аудит хийлгэсэн ШШГЕГ-ын харьяа 27 хорих анги, ШГА, ТӨААТҮГ-т нийт 37,436.0 мянган төгрөгийн 6 төлбөрийн акт, 38,001.6 мянган төгрөгийн 5 албан шаардлага, 215,772.6 мянган төгрөгийн 53 зөвлөмж өгч, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд 413,906.7 мянган төгрөгийн 25 залруулга хийгдэж, 5,590.0 мянган төгрөгийн 97 толгой малыг холбогдох шийдвэргүй акталсанд хариуцлага тооцсон зэрэг нийт 710,706.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна. Үүнд:

1.Төлбөрийн акт

Нийт 37,436.0 мянган төгрөгийн 6 төлбөрийн акт тогтоосноос 32,605.9 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөө дутуу биелүүлсэнтэй холбоотой, 3,608.2 мянган төгрөг нь ажилчдын цалингаас ХХОАТ суутгасан боловч дутуу тайлагнасантай холбоотой, 1,221.9 мянган төгрөгийн анхан шатны баримтгүй, хууль эрх зүйн үндэслэлгүй зардал гарсантай холбоотой акт байна.

2.Албан шаардлага

Нийт 38,001.6 мянган төгрөгийн 5 албан шаардлага тогтоосноос 11,789.0 мянган төгрөг нь хөрөнгө худалдан авах болон хөрөнгийн бүртгэлтэй холбоотой, 11,570.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, 14,602.7 мянган төгрөгийн худалдан авах ажиллагаатай холбоотой, 39.9 мянган төгрөгийн тайлагналын алдаатай холбоотой албан шаардлага байна.

Эрсдэл

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, хөрөнгийн ашиглал гарах, санхүүгийн тайлан тодруулгууд зөрөх, НББ-ийн тухай хууль зөрчигдөх

Зөвлөмж

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12, МУ-ын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан журмын 8 дугаар зүйлийн 8.1-д санхүүгийн тайлангийн аудитаар тавьсан акт, албан шаардлагын биелэлтийг тогтоосон хугацаанд хариуцагчаас албан бичгээр гаргуулан авах ба завсрын аудитаар бид давтан шалгана" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг танилцуулсан болно